



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 333

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах, бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 1 дэх заалт, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.3, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 686,229,700.00 (зургаан зуун наян зургаан сая хоёр зуун хорин есөн мянга долоон зуун) төгрөгийн балансын үнэ, 5,718,580.83 (таван сая долоон зуун арван найман мянга таван зуун наян төгрөг наян гурван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг данс бүртгэлээс хасаж залруулан, Дорнод аймаг дахь Шүүхийн шинжилгээний албаны үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал, бригадын генерал Д.Батжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг данснаас хасах, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

000675

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2020 оны 0 дугаар сарын 06-ны өдрийн
 333 дугаар тогтоолын хавсралт



ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ХАРЬАА
 ДОРНОД АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНД
 БҮРТГЭХ ХӨРӨНГӨ

| Д/д | Үндсэн хөрөнгийн нэр, байршил | Ашиглалтад орсон огноо | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Балансын нийт дүн /төгрөг/ | Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/ | Үлдэгдэл өртөг /төгрөг/ |
|-----|--|------------------------|-------------|------------|----------------------------|--------------------------------|-------------------------|
| 1 | Конторын барилга байгууламж /2 давхар, Дорнод аймаг, Хэрлэн сум, 4-р баг, Зангиатын 3-321 А/ | 2019.12.25 | м.кв | 408 | 686,229,700.00 | 5,718,580.83 | 680,511,119.17 |
| | Нийт дүн | | | | 686,229,700.00 | 5,718,580.83 | 680,511,119.17 |

/зургаан зуун наян сая таван зуун арван нэгэн мянга нэг зуун арван есөн төгрөг арван долоон мөнгө/